



**ХОВД АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**



***Ховд аймгийн хүн ам, өрхийн
үндсэн үзүүлэлтүүд төлөв
байдал танилцуулга***

2015 он

Агуулга

Оршил

Судалгааны зорилго

Судалгааны агуулга

Ойлголт тодорхойлолт

Судалгааны хэсэг

Хүн амын тоо сумдаар

Хүн амын өсөлт

Хүн амын тоо насны бүлэг, хүйсээр

Хүн амын нас, хүйсийн суварга 2010, 2014 он

Хүн амын нас хүйсийн бүтэц

Хүн ам зүйн ачаалал

- Хүн ам зүйн ачаалал сумаар

Дундаж наслалт

Төрөлт

Нас баралт

Өрхийн үзүүлэлтүүд

Гэрлэлт, цуцлалт

Шилжилт хөдөлгөөн

Дүгнэлт

Ашигласан материал

ОРШИЛ

Хүн ам зүйн судалгаанд хүн амын нас, хүйсийг судлах нь хүн ам, нийгэм, эдийн засгийн бодлого боловсруулах, хүн амын хүчин зүйлсийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинжилгээнд тусгахад чухал ач холбогдолтой. Хүн амын нас, хүйсийн байдал нь нийгэм, эдийн засаг, соёлын асуудлуудтай нягт холбоотой байдаг учраас түүнийг шинжлэх шаардлагатай байдаг. Тухайлбал сургуульд хамрагдалт, ажиллах хүчний нөөц, гэрлэх, төрөх, шилжих гэхмэт.

Судалгааны зорилго:

Энэхүү судалгаанд Ховд аймгийн 2010-2014 оны хүн амын тоо, өсөлтийн өөрчлөлт, нас хүйсийн бүтэц, хүн амын төрөлт, дундаж наслалт, өрхийн өсөлт, хүн амын шилжилт хөдөлгөөн гэх зэрэг хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүд, тэдгээрт гарсан өөрчлөлт болон хүн амын нийгмийн зарим үзүүлэлтүүдийн талаархи санал дүгнэлт гаргахийг зорилоо.

Судалгааны агуулга:

Судалгааг гаргахын тулд 2010-2014 оны суурин хүн амын жилийн эцсийн тайлан, Хүн амын ердийн хөдөлгөөний тайлан, Хүн амын шилжилт хөдөлгөөний тайлан мэдээний үзүүлэлтийг ашиглан судалгааг хийлээ.

Ойлголт, тодорхойлолт

“Хүн амын тоо” гэдэг нь тодорхой хугацаанд тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоог илэрхийлнэ. Хүн амын тоог бэлэн болон суурин хүн амаар тооцдог.

Суурин хүн ам: Тухайн засаг захиргааны нэгжид 183 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар оршин сууж байгаа хүн амыг хэлнэ.

Өрх. Нэг орон байранд хамт амьдардаг. Нэгдмэл төсөвтэй. Хүнс амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо ураг төрлийн холбоотой, хамаатан садан, зарим гишүүд нь огт хамааралгүй, эсвэл эдгээрийн аль алинаас нь бүрдсэн байж болно. Өрх гэдэг нь гэр бүл гэсэн ойлголтоос ялгаатай. Нэг өрхөд нэг болон хэд хэдэн гэр бүл амьдарч байж болно.

Хүн амын цэвэр өсөлт, бууралт: Тодорхой хугацааны туршид хүн амын тооны эерэг өөрчлөлтийг хүн амын өсөлт, сөрөг өөрчлөлтийг хүн амын бууралт гэнэ.

Дундаж наслалт: Шинээр төрсөн хүүхдийн цаашид үргэлжлэн амьдрах хугацааг (жил) хэлнэ.

Өрх толгойлсон эмэгтэйчүүд. Нөхөргүй, өрх толгойлон амьдарч байгаа эмэгтэйчүүдийг хүүхэдтэй эсэхийг харгалзахгүйгээр хамруулна.

Бүтэн ба хагас өнчин хүүхдэд. Эцэг эх нь хоёулаа нас барсан хүүхдийг бүтэн өнчинд, эцэг, эх хоёрын аль нэг нь нас барсан хүүхдийг хагас өнчинд тооцно.

Төрөх үеийн хүйсийн харьцаа. Энэ нь төрсөн эрэгтэй хүүхдийн тоог төрсөн эмэгтэй хүүхдийн тоонд харьцуулсан харьцаа юм.

Нас баралтын ерөнхий коэффициент. Энэ нь 1000 хүн ам тутамд ноогдох тухайн жилд нас барсан хүний тоог илэрхийлдэг бөгөөд түүнийг тооцохдоо нас барсан хүний тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулж 1000-аар үржүүлдэг.

Гэрлэлт. Тухайн нутаг дэвсгэрийн засаг захиргааны нэгжид гэр бүл болсноо бүртгүүлсэн хүмүүсийг гэрлэсэнд тооцно.

Цуцлалт. Гэрлэлтээ зохих шатны шүүхээр цуцлуулж, цуцлалтаа бүртгүүлсэн бол гэр бүлээ цуцалсанд тооцно.

1000 хүн амд ноогдох үзүүлэлтийг тодорхойлохдоо тухайн үзүүлэлтийг жилийн дундаж хүн амын тоонд харьцуулна.

Жилийн дундаж хүн амын тоог тухайн оны эхний болон эцсийн хүн амын тооны нийлбэрийг 2-т хувааж тодорхойлно.

Ховд аймгийн нутаг дэвсгэр болон нийт хүн амын тоо, сумдаар

Сумын нэр	Нутаг дэвсгэр /км ² /	Нийт хүн амын тоо				
		2010	2011	2012	2013	2014
Алтай	13144	3165	3127	3022	3046	3046
Булган	8104	9266	9266	9018	9203	9547
Буюнт	3759	2958	2875	2647	2871	3210
Дарви	5604	2649	2710	2712	2730	2777
Дөргөн	4128	2885	2873	2874	2879	2907
Дуут	2146	2043	2041	1960	1968	1959
Зэрэг	2524	3084	3131	3080	3105	3078
Манхан	4330	4001	4004	4001	4014	4011
Мянгад	3258	3502	3541	2128	3377	2177
Мөст	3927	3447	3289	3162	3097	3033
Мөнххайрхан	2554	2238	2225	3415	2119	3449
Үенч	7476	4541	4440	4142	4158	4125
Ховд	2830	3189	3131	3107	3290	3343
Цэцэг	3491	2492	2585	2639	2776	2850
Чандмань	6016	2956	3001	2885	2874	2865
Эрдэнэ-бүрэн	2772	2635	2556	2378	2368	2373
Жаргалант	70	27153	27538	25279	26342	26729
Бүгд	76133	82204	82333	78449	80217	81479

Ховд аймгийн (хүн амын өсөлт, 2010-2014 он) нийт хүн амын динамик судалгаа

Он	Нийт хүн ам	Динамик судалгаа		
		абсолют цэвэр өсөлт(мян.төг)	өсөлтийн хурд(%)	цэвэр өсөлтийн хурд(%)
2010	82204	-424	0.99	-0.5
2011	82333	129	1.00	0.2
2012	78449	-3884	0.95	-4.7
2013	80217	1768	1.02	2.3
2014	81479	1262	1.02	1.6

Дээрх динамик судалгаанаас харахад:


2010-2011 онд нийт хүн ам 0.2% буюу 129 хүнээр өссөн

2011-2012 онд нийт хүн 4.7 % буюу 3884 хүнээр буурсан

2012-2013 онд нийт хүн ам 2.3 %-иар буюу 1768 хүнээр өссөн

2013-2014 онд нийт хүн ам 1.6 %-иар буюу 1262 хүнээр өссөн байна.

Ховд аймгийн нийт хүн амын өсөлт, бууралтыг графикаар харуулбал:




Дээрх хүснэгтээс харахад хүн ам 2008-2010 он хүртэл буурч байгаад 2011 онд өсөж, 2012 онд дахин буураад түүнээс хойш өссөн байна. Дээрх хүснэгтээс харахад Ховд аймгийн хүн ам шилжин явалт өссөнтэй холбоотойгоор 2012 онд хамгийн бага байсан бол түүнээс хойш тогтмол өсөлттэй байна.

Суурин хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр /2010-2014/

Насны бүлэг	2010		2011		2012		2013		2014	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Бүгд	82204	41379	82333	41523	78449	39454	80217	40358	81479	40850
0-4	8515	4117	8840	4271	8914	4308	9253	4499	9755	4698
5-9	8259	4064	7944	3924	7689	3789	8079	3946	8292	4059
10-14	9475	4631	9136	4476	8249	4050	8015	3955	7729	3819
15-19	9554	4762	9460	4706	8957	4486	9022	4513	8784	4330
20-24	8892	4451	8980	4450	8322	4091	8151	4044	8167	4025
25-29	6857	3374	6952	3492	6218	3109	6594	3246	6875	3359
30-34	6240	3121	6169	3088	5742	2813	5775	2850	5772	2821
35-39	5785	3003	5766	3002	5466	2817	5635	2874	5679	2867
40-44	5050	2556	5132	2598	5009	2522	5090	2554	5193	2635
45-49	4256	2167	4385	2241	4218	2191	4330	2253	4377	2285
50-54	3232	1667	3319	1718	3457	1754	3618	1870	3831	1981
55-59	1895	1015	2093	1114	2117	1125	2398	1257	2639	1407
60-64	1241	699	1223	698	1291	717	1386	768	1529	835
65+	2953	1752	2934	1745	2800	1682	2871	1729	2857	1729

Хүн амын нас, хүйсийн суварга 2010, 2014 он



Хүн ам насны бүлгээр, хүйсээр /хувь/

Насны бүлэг	2010		2011		2012		2013		2014	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	49.7	50.3	49.6	50.4	49.7	50.3	49.7	50.3	49.9	50.1
0-4	5.4	5.0	5.5	5.2	5.9	5.5	5.9	5.6	6.2	5.8
5-9	5.1	4.9	4.9	4.8	5.0	4.8	5.2	4.9	5.2	5.0
10-14	5.9	5.6	5.7	5.4	5.4	5.2	5.1	4.9	4.8	4.7
15-19	5.8	5.8	5.8	5.7	5.7	5.7	5.6	5.6	5.5	5.3
20-24	5.4	5.4	5.5	5.4	5.4	5.2	5.1	5.0	5.1	4.9
25-29	4.2	4.1	4.2	4.2	4.0	4.0	4.2	4.0	4.3	4.1
30-34	3.8	3.8	3.7	3.8	3.7	3.6	3.6	3.6	3.6	3.5
35-39	3.4	3.7	3.4	3.6	3.4	3.6	3.4	3.6	3.5	3.5
40-44	3.0	3.1	3.1	3.2	3.2	3.2	3.2	3.2	3.1	3.2
45-49	2.5	2.6	2.6	2.7	2.6	2.8	2.6	2.8	2.6	2.8
50-54	1.9	2.0	1.9	2.1	2.2	2.2	2.2	2.3	2.3	2.4
55-59	1.1	1.2	1.2	1.4	1.3	1.4	1.4	1.6	1.5	1.7
60-64	0.7	0.9	0.6	0.8	0.7	0.9	0.8	1.0	0.9	1.0
65+	1.5	2.1	1.4	2.1	1.4	2.1	1.4	2.2	1.4	2.1

Сүүлийн 5 жилийн динамикийг харахад хүн амд эзлэх эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдийнхээс 0.8-0.2 функтээр тогтмол өндөр байна.


Нас хүйсийн бүтцийн үзүүлэлтүүд

- Залуу ба хөгшин хүн амын хувь

он	Хүүхэд /0-15/	Хөгшид /60+/	Хөдөлмөрийн насны хүн ам /16-59/	Нийт хүн ам	Залуу хүн амын эзлэх хувь	Хөгшин хүн амын эзлэх хувь	Хүүхдийн эзлэх хувь
2010	28263	4194	49747	82204	60.5	5.1	34.4
2011	27915	4157	50261	82333	61.0	5.0	33.9
2012	26640	4091	47718	78449	60.8	5.2	34.0
2013	27108	4257	48852	80217	60.9	5.3	33.8
2014	27404	4386	49689	81479	61.0	5.4	33.6

Дээрх хүснэгтэнд хөдөлмөрийн насны хүн ам, хүүхэд, хөгшидийг нийт хүн амын хэдэн хувийг эзэлж байгааг жил бүрээр харууллаа. Үүнээс үзэхэд нийт хүн амын ихэнх хувийг 16-59 насныхан эзэлж байна. Залуу хүн амын эзлэх хувь 2010 оноос тогтмол өсөлттэй байна. Мөн 0-6 насны хүүхдийн эзлэх хувь буурсан байна. Энэ нь төрөлт багассантай холбоотой. 60-с дээш насны хүн амын эзлэх хувь 2010-2014 оны хүртэл жил бүр нийт хүн амын 5-5.4%-ийг эзэлж байна.

- Хүн ам зүйн ачаалал



2010-2014 оны байдлаар хүн ам зүйн ачаалал 2010 онд хамгийн өндөр буюу хөдөлмөрийн насны 100 хүн амд хөдөлмөрийн бус насны 65 хүн ногдож байна. Энэ үзүүлэлт 2011 онд хөдөлмөрийн насны 100 хүн амд хөдөлмөрийн бус насны 64 хүн ам

ногдож байсан бол 2014 оны байдлаар хөдөлмөрийн насны 100 хүн амд хөдөлмөрийн бус насны 64 хүн ногдож байсан байна.

Хүн ам зүйн ачааллыг сумдаар харвал :

Сумын нэр	Насны бүлэг			Хүн ам зүйн ачаалал
	0-15	16-59	60+	
Жаргалант	8129	17174	1426	55.64
Алтай	1088	1815	143	67.82
Булган	3259	5717	571	66.99
Буянт	1057	1948	205	64.78
Дарви	987	1652	138	68.10
Дөргөн	1124	1642	141	77.04
Дуут	665	1183	111	65.60
Зэрэг	1060	1834	184	67.83
Манхан	1513	2318	180	73.04
Мөнххайрхан	734	1314	129	65.68
Мөст	1075	1768	190	71.55
Мянгад	1226	2049	174	68.33
Үенч	1504	2411	210	71.09
Ховд	1297	1886	160	77.25
Цэцэг	1021	1705	124	67.16
Чандмана	968	1728	169	65.80
Эрдэнэбүрэн	697	1545	131	53.59

Хүн ам зүйн ачааллыг сумдаар авч үзвэл хамгийн өндөр хүн ам зүйн ачаалалтай байгаа сум нь Ховд сум буюу 77.2 байгаа бол хамгийн бага ачаалалтай байгаа нь Эрдэнэбүрэн сум буюу 53.5 байна. Сумдын дундаж хүн ам зүйн ачаалал 67 байна.

- **Хөгшрөлтийн индекс**



Ховд аймгийн хувьд хөгшрөлтийн индекс 2010 онд 14.8 байсан бол 2012 онд 15.3 болж 2010 оныхоос 0.5 пунктаар өссөн бол 2014 онд 16.0 болж 2010 оныхоос 1.2 пунктээр, 2012 оныхоос 0.7 пунктээр тус тус өссөн байна. Дээрх үзүүлэлтээс харахад Ховд аймгийн хүн амын бүтэц залуу бүтэцтэй гэдэг нь харагдаж байна.

- Хүйсийн харьцаа

	2010	2011	2012	2013	2014
Эрэгтэй	40825	40825	38993	39859	40629
Эмэгтэй	41379	41523	39456	40358	40850
Хүйсийн харьцаа	98.66	98.32	98.83	98.76	99.46

Ховд аймгийн хэмжээнд 2010 онд хүйсийн харьцаа нь 98.6 байсан бол 2014 онд 99.4 болсон байна. 2010 оноос хойш хүйсийн харьцаа нь харьцангуй тогтворжсон байна.

- Дундаж наслалт

Аймаг	2010	2011	2012	2013
Баян-Өлгий	68.9	70.9	71.7	72.1
Говь-Алтай	65.2	67.1	67.8	68.2
Завхан	65.5	67.5	68.2	68.6
Увс	64.7	66.6	67.3	67.7
Ховд	67.9	69.9	70.7	71.1
Баруун бүс	66.4	68.4	69.1	69.5
Улсын дүн	68.0	68.3	68.7	69.1

Хүн төрснөөс хойш хэдэн жил үргэлжлэн амьдрах хугацааг харуулдаг дундаж наслалт нь баруун бүсийн хувьд 69.5 байна. Төрөлтөөс тооцсон дундаж наслалт манай аймгийн хувьд 71.1 болж өмнөх оныхоос 0.4 насаар өсчээ. Баруун бүсэд Ховд аймаг дундаж наслалтаар 2-рт орж байна. Ховд аймгийн дундаж наслалт бүсийн дунджаас 0.6-аар илүү байгаа бол улсын дунджаас 1 насаар илүү байна.

Төрөлт

Он	Төрөлт
2010	2012
2011	2312
2012	2358
2013	2444
2014	2376



Төрөх насны эмэгтэйчүүдийн тоо 2010-2014

Нас	2010	2011	2012	2013	2014
15-19	4762	4706	4486	4513	4330
20-24	4451	4450	4091	4044	4025
25-29	3374	3492	3109	3246	3359
30-34	3121	3088	2813	2850	2821
35-39	3003	3002	2817	2874	2867
40-44	2556	2598	2522	2554	2635
45-49	2167	2241	2191	2253	2285
Бүгд	23434	23577	22029	22334	22322

Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент

Нас	Төрөх насны эмэгтэй	Төрсөн хүүхэд	НБТК
15-19	4330	49	11
20-24	4025	592	147
25-29	3359	723	215
30-34	2821	601	213
35-39	2867	318	111
40-44	2635	77	29
45-49	2285	16	7
50-54	1981	-	-
Бүгд	24303	2376	98

Төрөх насны 22322 эмэгтэй байгаа нь урьд оны мөн үеийнхээс төрөх насны эмэгтэй хүний тоо 0.05 хувиар буюу 12 эмэгтэйгээр буурсан байна. 2014 онд 2376 хүүхэд төрсөн нь өмнөх оныхоос 2.8 хувь буюу 68 хүүхдээр буурсан байна. Төрсөн

эмэгтэйчүүдийг насны бүлгээр харвал хамгийн өндөр төрөлтэй бүлэг нь 25-29 насныхан хэвээр байна.

Төрсөн хүүхдийн тоо хүйсээр

	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Нийт	2376	1242	1134
Алтай	77	29	48
Булган	265	149	116
Буянт	95	56	39
Дарви	92	45	47
Дуут	41	24	17
Дөргөн	95	55	40
Жаргалант	874	439	435
Зэрэг	76	41	35
Манхан	102	55	47
Мянгад	112	58	54
Мөнххайрхан	67	34	33
Мөст	69	36	33
Ховд	75	32	43
Цэцэг	101	54	47
Чандмань	70	38	32
Эрдэнэбүрэн	50	30	20
Үенч	115	67	48

Нийт 2376 хүүхэд төрсний 52.3 хувь нь буюу 1242 хүүхэд нь эрэгтэй бол үлдсэн 47.7 хувь нь буюу 1134 хүүхэд нь эмэгтэй хүүхэд төрсөн байна. Сумуудаас хамгийн их хүүхэд төрсөн сум нь аймгийн төвийн сум болох Жаргалант сум байгаа бол хамгийн бага хүүхэд төрсөн нь Дуут сум байна.

Хүүхэд эмэгтэйн харьцаа

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014
0-4 насны хүүхэд	8515	8840	8914	9253	9755
15-49 насны эмэгтэйчүүд	23434	23577	22029	24204	22322
Хүүхэд-эмэгтэйн харьцаа	363.4	374.9	404.6	382.3	437



Хүүхэд эмэгтэйн харьцаа нь тухайн жилийн нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэй тутамд ногдох 0-4 насны хүүхдийн тоо бөгөөд Ховд аймагт уг үзүүлэлт нь 2007 онд 337 байсан бол 2014 онд 437 болж 100-р өссөн байна.

Нас баралт

- Нас баралтын ерөнхий коэффициент

Үзүүлэлтүүд	2010	2011	2012	2013	2014
Нийт хүн ам	82204	82333	78449	80217	81479
Нас баралт	473	283	466	489	489
Нас баралтын ерөнхий коэффициент	5.8	3.4	5.9	6.1	6



Ховд аймгийн нас баралтын коэффициентийг 2008-2014 оны хооронд судлахад хамгийн бага нь 2011 онд 1000 хүнд 3 хүн ногдож байсан бол 2014 оны байдлаар 6 болж өссөн байна.

Нас баралт сумдаар, хүйсээр

Сумын нэр	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
ДҮН	489	284	205
Алтай	28	18	10
Булган	55	30	25
Буянт	16	6	10
Дарви	7	6	1
Дуут	6	6	-
Дөргөн	17	8	9
Жаргалант	174	99	75
Зэрэг	21	13	8
Манхан	33	23	10
Мянгад	20	14	6
Мөнххайрхан	12	7	5
Мөст	21	8	13
Ховд	9	6	3
Цэцэг	15	6	9
Чандмань	15	11	4
Эрдэнэбүрэн	18	10	8
Үенч	22	13	9

Нас барсан нийт хүмүүсийн 58.1 хувь буюу 284 нь эрэгтэй, 41.9 хувь буюу 205 нь эмэгтэйчүүд байна. Нас баралт өндөр байгаа сум нь Жаргалант сум байна. Энэ нь хүн амын тоо ихтэй байдагтай холбоотой.

Нас баралт насны бүлэг, хүйсээр

Насны бүлэг	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	489	284	205
0-4	26	15	11
5-9	13	4	9
10-14	5	3	2
15-19	9	7	2
20-24	19	13	6
25-29	13	10	3
30-34	15	15	0
35-39	11	10	1
40-44	23	20	3
45-49	33	22	11
50-54	42	29	13
55-59	41	31	10
60+	239	105	134


Нас баралтыг хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдийнхээс харьцангуй өндөр байна. Нас баралтыг насны бүлгээр харвал залуу насанд эрэгтэйчүүдийн нас баралт их байж байгаад насны бүлэг ахихад эмэгтэйчүүдийн нас баралт нэмэгдэж ирж байна. Энэ нь эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс их байдаг холбоотой юм.

Өрхийн үзүүлэлтүүд :

Ховд аймгийн нийт өрхийн тоог өнгөрсөн онтой нь харьцуулахад:

Сумын нэрс	Өрхийн тоо		цэвэр өсөлт/ш/	өсөлт, бууралт хувиар
	2013	2014		
Алтай	765	766	1	1.00
Булган	2221	2243	22	1.01
Буянт	790	859	69	1.09
Дарви	698	714	16	1.02
Дөргөн	692	713	21	1.03
Дуут	508	518	10	1.02
Зэрэг	780	780	0	1.00
Манхан	947	958	11	1.01
Мөнххайрхан	842	575	-267	-0.68
Мөст	795	787	-8	-0.99
Мянгад	563	872	309	1.55
Үенч	1032	1004	-28	-0.97
Ховд	739	759	20	1.03
Цэцэг	742	773	31	1.04
Чандмань	727	734	7	1.01
Эрдэнэбүрэн	630	640	10	1.02
Жаргалант	7147	7377	230	1.03
Бүгд	20618	21072	454	1.02

2013-2014 онд өрхийн тоо хамгийн их нэмэгдсэн нь Мянгад сум 54%-иар буюу 309 өрхөөр нэмэгдсэн байна. Харин Мөнххайрхан сум 32%-иар буюу 267 өрхөөр буурсан байна. Аймгийн хэмжээнд нийт өрхийн тоо 2.2% буюу 454 өрхөөр нэмэгдсэн байна.



Нийт өрхийн 35.0 хувь буюу 7377 өрх нь аймгийн төв буюу Жаргалант суманд, 10.6 хувь буюу 2243 өрх нь Булган суманд, 4.8 хувь буюу 1004 өрх Үенч суманд амьдарч байхад хамгийн бага 2.5 хувь буюу 518 өрх Дуут суманд амьдарч байна.

Гэрлэлт, цуцлалтын үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2010	2011	2012	2013	2014
Гэрлэлт	396	508	678	741	739
Гэрлэлтийн бохир коэффициент	4.8	6.2	8.6	9.2	9.1
Гэр бүл салалт	46	58	48	70	37
Гэр бүл салалтын бохир коэффициент	5.6	7	6.1	8.7	4.5

Нийт 739 хос гэрлэлтээ бүртгүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 0.2 хувиар буюу 2 гэр бүлээр буурсан байна.

Гэрлэлт, цуцлалтын үзүүлэлтүүд сумдаар

Сум	2013			2014			Харьцуулалт %		
	Гэрлэлт	Цуцлалт	Үрчлэлт	Гэрлэлт	Цуцлалт	Үрчлэлт	Гэрлэлт	Цуцлалт	Үрчлэлт
Алтай	20	3	2	17	-	-	85	-	-
Булган	63	2	9	67	3	4	106.3	150	44.4
Буянт	24	3	10	29	2	3	120.8	66.7	30
Дарви	20	1	3	23	-	1	115	-	33.3
Дөргөн	27	1	4	70	1	7	259.3	100	175
Дуут	10	3	1	7	1	-	70	33.3	-
Зэрэг	16	1	3	21	1	2	131.3	100	66.7
Манхан	28	3	1	28	1	2	100	33.3	200
Мөст	26	1	3	14	-	-	53.8	-	-
Мөнххайрхан	18	1	2	19	-	4	105.6	-	200
Мянгад	31	1	-	19	1	7	61.3	100	-
Үенч	38	-	3	51	1	5	134.2	-	166.7
Ховд	26	1	5	21	-	3	80.8	-	60
Цэцэг	34	-	2	31	-	4	91.2	-	200
Чандмань	26	3	1	28	1	1	107.7	33.3	100
Эрдэнэбүрэн	17	-	4	21	-	-	123.5	-	-
Жаргалант	317	46	23	273	25	25	86.1	54.3	108.7
Бүгд	741	70	76	739	37	68	99.7	52.9	89.5

Энэ онд 739 хос гэр бүл болсоноо бүртгүүлж, 37 хос гэр бүлээ цуцлуулж, 68 хүүхэд үрчлэгдсэн байна. Өнгөрсөн онтой харьцуулахад гэрлэлт 0.2 хувиар буюу 2 хосоор, гэр бүл цуцлалт 47.1 хувь буюу 33 хосоор, үрчлэлт 11.7 хувь буюу 8 хүүхдээр буурчээ.

Өрхийн зарим үзүүлэлтүүд

Сум	Бүтэн өнчин хүүхдийн тоо	Хагас өнчин хүүхдийн тоо	Өрх толгойлсон эх
Ховд	110	1596	3011
Алтай сум	-	40	135
Булган сум	7	214	139
Буянт сум	3	18	122
Дарви сум	5	52	78
Дөргөн сум	6	56	115
Дуут сум	2	29	74
Жаргалант сум	50	721	1425
Зэрэг сум	2	30	96
Манхан сум	5	62	150
Мөнххайрхан сум	7	35	93
Мөст сум	1	44	127
Мянгад сум	6	50	54
Үенч сум	3	94	119
Ховд сум	10	42	40
Цэцэг сум	-	45	60
Чандмань сум	3	47	114
Эрдэнэбүрэн сум	-	17	70

Аймгийн хэмжээнд нийт 21072 өрх байгаагын 14.3 хувь нь буюу 3011 өрх эмэгтэй тэргүүлэгчтэй байна. Өрх толгойлсон эхчүүдийн 47.3 хувь нь аймгийн төв буюу Жаргалант суманд байна.

2014 оны байдлаар нийт 1596 хагас өнчин хүүхэд, 110 бүтэн өнчин хүүхэд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо:

Ховд аймагт нийт 3025 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагын 1280 нь буюу 42.3 хувь нь эмэгтэйчүүд байна. Нийт иргэдээс 1104 буюу 36.5 хувь нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй бол үлдсэн 1921 буюу 63.5 хувь нь олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэд байна.

Олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэдийн 77.0 хувь нь буюу 1482 хүн нь өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо сумаар, төрлөөр

	Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	Эмэгтэй	Төрөлхийн	Хөгжлийн бэрхшээлийн төрөл				
				Олдмол				
				Өвчнөөр		Осол гэмтлээр		
				Ердийн өвчин	Мэргэжлээс шалтгаалсан өвчин	Зам тээврийн осол	Үйлдвэрийн осол	Ахуйн осол
Ховд	3025	1280	1104	1358	124	67	87	285
Алтай сум	62	26	57	5	0	0	0	0
Булган сум	312	154	154	92	28	6	0	32
Буянт сум	100	34	37	11	3	0	12	37
Дарви сум	143	46	29	68	5	0	0	41
Дөргөн сум	99	45	54	24	0	0	0	21
Дууг сум	90	37	33	57	0	0	0	0
Жаргаланд сум	1048	501	353	546	59	26	34	30
Зэрэг сум	110	39	27	58	0	10	0	15
Манхан сум	249	88	118	57	0	20	18	36
Мөнххайрхан сум	84	33	39	33	0	0	0	12
Мөст сум	98	37	7	91	0	0	0	0
Мянгад сум	131	57	37	47	10	4	18	15
Үенч сум	152	38	30	77	19	0	0	26
Ховд сум	64	34	13	51	0	0	0	0
Цэцэг сум	83	28	43	38	0	0	0	2
Чандмань сум	86	38	33	47	0	1	1	4
Эрдэнэбүрэн сум	114	45	40	56	0	0	4	14

Аймаг , нийслэл хоорондын шилжилт хөдөлгөөн

Тайлант онд Улсын бүртгэлийн хэлтэст 738 хүн шилжин ирснээ, 1789 хүн шилжин явснаа бүртгүүлсэн нь урьд оны мөн үеийнхээс шилжин ирэлт 2.4 хувиар буюу 17 хүнээр нэмэгдсэн бол шилжин явалт нь 7.8 хувиар буюу 151 хүнээр буурсан байна. Шилжин ирэлт нэмэгдэж, шилжин явалт буурч байгаа нь хүн ам өсөх таатай нөхцөл юм.

Нийт шилжих хөдөлгөөн оролцогчдын 78.6 хувь буюу 1407 хүн нь 16-аас дээш насны хүн ам буюу насанд хүрэгчид байгаа бол үлдсэн 21.4 хувь буюу 382 хүн ам 16 хүртэлх насны хүүхдүүд байна.

Аймаг , нийслэл хоорондын шилжилт хөдөлгөөн

Д/Д	Аймаг,нийслэл	Өөр аймаг нийслэл руу шилжин явсан			Өөр аймаг нийслэлээс шилжин ирсэн		
		Нийт	Насанд хүрэгч	16-с доош насны хүүхэд	Нийт	Насанд хүрэгч	16-с доош насны хүүхэд
1	Архангай	6	3	3	6	4	2
2	Баянөлгий	76	50	26	80	57	23
3	Баянхонгор	2	1	1	5	3	2
4	Булган	6	3	3	8	4	4
5	Говьалтай	20	14	6	34	24	10
6	Дорноговь	26	12	14	-	-	-
7	Дорнод	2	1	1	1	1	-
8	Дундговь	2	1	1	-	-	-
9	Завхан	19	16	3	14	11	3
10	Өвөрхангай	4	3	1	13	7	6
11	Өмнөговь	5	4	1	8	5	3
12	Сүхбаатар	5	3	2	-	-	-
13	Сэлэнгэ	49	30	19	29	22	7
14	Төв	28	19	9	3	2	1
15	Увс	27	23	4	55	41	14
16	Хөвсгөл	6	3	3	6	5	1
17	Хэнтий	8	4	4	3	2	1
18	Дархан-уул	61	45	16	44	25	19
19	Улаанбаатар	1401	1145	256	400	287	113
20	Орхон	25	21	4	21	17	4
21	Говьсүмбэр	11	6	5	8	4	4
	Дүн	1789	1407	382	738	521	217

Дүгнэлт

Ховд аймгийн хүн амын тоо сүүлийн илүүдэд тогтмол өсч байна. Хүн амыг насны бүтцийнх нь хувьд авч үзвэл залуу насныхны эзлэх хувь буюу 16-59 насныхан өндөр байгаа нь Ховд аймгийн хүн амын бүтэц залуу байгаа буюу хүн ам зүйн цонх үе эхэлсэн байгааг харуулж байна.

Хүн ам зүйн ачаалал буюу хөдөлмөрийн насны 100 хүн амд ногдох хөдөлмөрийн бус насны хүн амын тоо буурч байгаа нь эерэг үзүүлэлт юм. Энэ нь хүн амын ажил эрхлэлт нэмэгдсэнийг харуулж байна.

Хүн төрснөөс хойш хэдэн жил үргэлжлэн амьдрах хугацааг харуулдаг дундаж наслалт нь баруун бүсийн хувьд 69.5 байна. Төрөлтөөс тооцсон дундаж наслалт манай аймгийн хувьд 71.1 болж өмнөх оныхоос 0.4 насаар өсчээ. Баруун бүсэд Ховд аймаг дундаж наслалтаар 2-рт орж байна. Ховд аймгийн дундаж наслалт бүсийн дунджаас 0.6-аар илүү байгаа бол улсын дунджаас 1 насаар илүү байна.

Төрөх насны 22322 эмэгтэй байгаа нь урьд оны мөн үеийнхээс төрөх насны эмэгтэй хүний тоо 0.05 хувиар буюу 12 эмэгтэйгээр буурсан байна. 2014 онд 2376 хүүхэд төрсөн нь өмнөх оныхоос 2.8 хувь буюу 68 хүүхдээр буурсан байна. Төрсөн эмэгтэйчүүдийг насны бүлгээр харвал хамгийн өндөр төрөлтэй бүлэг нь 25-29 насныхан хэвээр байна.

Нийт 2376 хүүхэд төрсний 52.3 хувь нь буюу 1242 хүүхэд нь эрэгтэй бол үлдсэн 47.7 хувь нь буюу 1134 хүүхэд нь эмэгтэй хүүхэд төрсөн байна.

Нас баралтыг хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдийнхээс харьцангуй өндөр байна. Нас баралтыг насны бүлгээр харвал залуу насанд эрэгтэйчүүдийн нас баралт их байж байгаад насны бүлэг ахихад эмэгтэйчүүдийн нас баралт нэмэгдэж ирж байна. Энэ нь эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийн их байдаг холбоотой юм.

Хүн амын төрөл, нас баралт, шилжилт хөдөлгөөн тогтворжсон байгаа нь хүн ам өсөх таатай нөхцөлийг бүрдүүлж байна.

Ашигласан материал

- Ховд аймгийн нийгэм эдийн танилцуулга 2010-2014 он
- Монгол улсын Статистикийн эмхтгэл 2010-2013 он
- Жилийн эцсийн хүн амын мэдээ
- www.1212.mn